

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос УИХ-ын сонгуулийн хуулийн хоёр төслийг Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намд ирүүлсэнтэй танилцан албан ёсны байр сууриа илэрхийлж байна.

Монгол улсад парламентын тогтолцоог боловсронгуй болгоход Сонгуулийн хууль их үүрэг гүйцэтгэдэг.

Хариуцлагын тогтолцоог бэхжүүлэн, парламентыг төлөвшүүлэхэд хуулийн төслийн хоёр хувилбарт чухал зарим санал дэвшигдсэн байна гэж үзэж байна. Тухайлбал, УИХ-ын сонгуульд нэр дэвшигч нь:

- **Нэр дэвшихээсээ өмнө орлогын мэдүүлгээ нээлттэй болгох;**
- **Банкны зээл, түүний батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;**
- **Татварын байгууллагын өмнө өргүй байх;**
- **Төрийн жинхэнэ албан хаагч УИХ-ын гишүүнд нэр дэвших бол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас чөлөөлөгдсөн байх;**
- **Нэр дэвшигчийн сонгуульд зориулж өгсөн хандивын хэмжээг хувь хүн 5 саяас, хуулийн этгээд 10 саяас хэтрүүлэхгүй байх;**
- **200 мянган төгрөгөөс дээш хандивыг ил болгох** зэрэг чухал

заалтууд орсоныг манай нам хариуцлагын тогтолцоог хөгжүүлэхийн төлөө байдаг намын хувьд дэмжиж байна.

Иргэний Зориг-Бүгд Найрамдах Нам УИХ-ын Сонгуулийн хуулийг боловсронгуй болгоход хэрэгтэй гэж үзсэн зургаан зүйл саналаа толилуулж байна.

- **Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын нэгдүгээр санал**

УИХ-ын сонгуулийг холимог системээр явуулах

Мажоритар тогтолцоо нь онолын хувьд нэгдмэл зохион байгуулалттай төвлөрсөн намууд үүсч хөгжих болон улс төрийн эрх мэдэл намын аппаратын гарт төвлөрөхийн эсрэг хүчтэй үйлчилдэг, хувь хүний эрх чөлөө, хувийн хариуцлага тод томруунаар гаргадаг.

Сонгуулийн пропорциональ тогтолцоо нь сонгогчдын олон янзын санал бодлыг хувь тэнцүү байдлаар төлөөлж чаддаг, тодруулбал сонгогчдыг төлөөлөх чадварыг парламентад илүү бүрдүүлдэг.

Энэ хоёр тогтолцоог оновчтой хослуулж чадвал сонгогчдын төлөөллийг бодитой хадгалсан парламентыг бүрдүүлнэ гэж манай нам үзэж байна.

- **Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын хоёрдугаар санал**

Улаанбаатар хотод ногдох УИХ-ын мандатын тоо 20 байгааг өөрчлөн наад зах нь 26 хүртэл нэмэгдүүлэх

Манай намын нэгдүгээр саналыг хүлээж авах боломжгүй гэж үзвэл одоогийн мажоритар тогтолцоог улам боловсронгуй болгох хэрэгтэй гэж үзэж байна.

2001 онд явагдсан Хүн амын тооллогоор Улаанбаатар хотын хүн ам 1996 оноос даруй 200 гаруй мянгаар нэмэгдэн 812,5 мянгад хүрч, улмаар сүүлийн хоёр жил албан бусаар бараг 1 сая-д хүрч байна. Иймд сонгогчдын тэгш эрх, төлөөллийг хангах зорилгоор Улаанбаатар хотод наад зах нь УИХ-ын 30-35 суудал шаардлагатай юм. Гэвч засаг захиргаа, нутаг

дэвсгэрийн онцлогийг харгалзан УИХ-ын 26-аас доошгүй мандатыг Улаанбаатар хотод хуваарилан өмнөх хэмжээнээс даруй 6 мандатаар нэмэгдүүлэх санал оруулж байна.

□ ***Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын гуравдугаар санал***

Нэр дэвшигч нь сонгогчдын 50-иас дээш хувийн саналыг авсан байх

Мажоритар системээр сонгогдох нэр дэвшигч нь дараахь саналын босгыг давсан нөхцөлд УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцох. Үүнд:

Энгийн олонхийн саналаар сонгох. Нэр дэвшигч сонгогдохын тулд нийт саналын 50-иас доошгүй хувийг авсан байх шаардлагатай. Үүнийг 50 хувь+1 санал гэсэн томъёогоор илэрхийлдэг. 2-оос дээш тооны нэр дэвшигч байгаад тэдний хэн нь ч эхний санал хураалтаар 50-иас дээш санал аваагүй тохиолдолд дахин санал хураалт явуулах нь энэ зарчимд нийцдэг.

□ ***Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын дөрөвдүгээр санал***

Сонгогч нь тухайн мандатын тооны хүрээнд хэдэн ч нэр дэвшигчийг сонгох эрхээр хангагдах

Сонгогч сонгуулийн саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдээс хэнийг нь дэмжиж буйгаа тухайн тойрог дахь УИХ-ын суудлын тоонд заавал захируулах бус мандатын тооны дотор хэдэн хүн сонгохоо өөрөө шийдэх байдлаар хуулинд өөрчлөлт оруулах.

Тухайлбал, 3 мандаттай тойрогт саналаа өгч байгаа сонгогч нь нэг эсвэл хоёр хүний төлөө саналаа өгч болох. Сонгогчдод нэр дэвшигчдээс зөвхөн хоёр нь эсвэл нэг нь л таалагдаж болно. Ийм учраас 3 хүний төлөө саналаа заавал өг гэж хуулиар сонгогчийг шахалтад оруулах нь хүний сонгох эрхийг ноцтой зөрчиж байгаа юм.

□ ***Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын тавдугаар санал***

Саналын хуудсанд нэр дэвшигчийн ард нам, эвслийн нэрийг бичихдээ сугалаа сугалуулан байрлуулах

Нэр дэвшигч, дэвшүүлж буй нам, эвслийн тэгш байдлыг хангах үүднээс саналын хуудсанд нам эвслийн дарааллыг Дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар бус (УИХ-ын Сонгуулийн хуулийн 32 дугаар зүйлийн 3) нам, эвслийн дунд сугалаа сугалуулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

□ ***Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын зургадугаар санал***

Хилийн чанадад амьдардаг монголчуудыг сонгуульд хамруулах

Хилийн чанадад амьдарч байгаа Монгол улсын харъяат иргэдийг сонгуульд хамрагдаж, санал өгөх бололцоогоор хангах талаар хуульд шинэ заалт оруулах саналтай байна. Албан бус мэдээллээр гадаадад 100 илүү мянган монгол иргэн амьдарч байна.

Ямар улсын аль хотод амьдардаг монголчууд хэддүгээр тойрогт хамрагдан саналаа өгөх боломжийг хангаж өгөх нь зүйтэй. Жишээлбэл, Өмнөт Солонгос улсын Сөүл хотод амьдардаг Монголчууд Улаанбаатар хотын эсвэл бусад аймгийн сонгуулийн тойргоос нэр дэвшигчдийн төлөө саналаа өгөх боломжтой байх гэсэн нийт зургаан зүйл санал гаргаж байна.

УИХ-ЫН ГИШҮҮН, НАМЫН ТЭРГҮҮН САНЖААСҮРЭНГИЙН ОЮУН

Лавлагаа:

1. Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.
2. УИХ-ын сонгуулийн хууль. 8 дугаар зүйл. Сонгуулийн тойрог түүнийг байгуулах.
 - Сонгуулийг нэг мандат бүхий тойргоор зохион байгуулж явуулна. (УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн санаачилсан хуулийн төслөөр нэг болон олон мандат бүхий тойргийг аль аль нь байж болохоор хоёр хувилбар хэлэлцүүлж байгаа)
 - Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө УИХ байгуулна. Аймгийн хүн амын тоо нь УИХ-ын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно.
 - Сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг УИХ тогтооно.